



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

**Компанийн 2017 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан,  
түүнд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.7 дахь заалт, 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2017 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.

**ХУРЛЫН ДАРГА**



**Ч.ПҮРЭВСҮРЭН**

**Компанийн 2017 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн  
хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх, 96 дугаар зүйлийн 96.5 дахь хэсэг, Монголын цахилгаан холбоо ХК-ийн Дүрмийн 7.8.7 дахь заалт 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан тэнцлийг дор дурдсанаар баталсугай:

1.1. Нийт хөрөнгийг **35,738,393,742** (гучин таван тэрбум долоон зуун гучин найман сая гурван зуун ерэн гурван мянга долоон зуун дөчин хоёр) төгрөгөөр, үүнээс эргэлтийн бус хөрөнгийг **17,270,317,614** (арван долоон тэрбум хоёр зуун далан сая гурван зуун арван долоон мянга зургаан зуун арван дөрөв) төгрөгөөр, эргэлтийн хөрөнгийг **18,468,076,127** (арван найман тэрбум дөрвөн зуун жаран найман сая далан зургаан мянга нэг зуун хорин долоо) төгрөгөөр;

1.2. Өр төлбөрийн нийт дүнг **6,789,451,893** (зургаан тэрбум долоон зуун наян есөн сая дөрвөн зуун тавин нэгэн мянга найман зуун ерэн гурав) төгрөгөөр;

1.3. Эзэмшигчийн өмчийг **28,948,941,848** (хорин найман тэрбум есөн зуун дөчин найман сая есөн зуун дөчин нэгэн мянга найман зуун дөчин найм) төгрөгөөр тус тус баталсугай.

2. Монголын цахилгаан холбоо ХК-ийн хараат бус аудитын байгууллагаар хийлгэсэн аудитын тайлан, дүгнэлтийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ПҮРЭВСҮРЭН



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

**Компанийн ТУЗ-ийн Аудитын хорооны тайлан,  
дүгнэлтийг батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7.8.7 дахь заалт, 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн Аудитын хорооны дүгнэлтийг тус баталсугай.

**ХУРЛЫН ДАРГА**



**Ч.ПҮРЭВСҮРЭН**



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

№ 04

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж,  
сонгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.6, 7.10 дахь заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан:

- Ердийн гишүүдэд:

- Г.Эрдэнэбулган
- Ц.Баяр-Эрдэнэ
- Ж.Цогтбаяр
- Д.Ариунтуяа
- Ч.Цэвэгдорж
- Т.Лхагвасүрэн

- Хараат бус гишүүдэд:

- Ж.Тамир
- Л.Болормаа
- Ц.Норовжамц

нарыг 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр тус тус сонгосугай.

2. Жон Гил Сон, Хан Жи Үн, Жү Хонг Сик, О.Хуягцогт нарыг Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүний үүрэгт ажлаас, Канг Ён Минийг Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний үүрэгт ажлаас 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгон тус тус чөлөөлж, бүрэн эрхийг нь дуусгавар болгосугай.

3. Компанийн үр ашигтай үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, холбогдох хууль, дүрэм, журмын дагуу ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

**ХУРЛЫН ДАРГА**



**Ч.ПҮРЭВСҮРЭН**



Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн  
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 05 тоот тогтоолын Хавсралт



### МЦХ ХК-ийн ТУЗ-ийн 2018 оны зардлын төсөв

/Нэгж: төгрөг/

	Зардлын төрөл	Тоо	Нэгж зардал	Давтамж	Нийт дүн
<b>1. Цалин, холбоо, тээврийн зардал</b>					
1	ТУЗ-ийн гишүүд	9	380,000.0	12	41,040,000.0
2	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	1	350,000.0	12	4,200,000.0
3	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын холбоо, тээврийн зардал	1	150,000.0	12	1,800,000.0
	Цалин, холбоо, тээврийн зардлын нийт дүн				47,040,000.0
<b>2. Бичиг хэрэг, ёслолын зардал</b>					
1	Бичиг хэргийн материал		90,000.0	6	540,000.0
2	Байрны түрээс		300,000.0	6	1,800,000.0
3	Хэвлэл		500,000.0	1	500,000.0
4	Ёслол ба бусад		150,500.0	12	1,806,000.0
	Бичиг хэрэг ба ёслолын зардлын нийт дүн				4,646,000.0
<b>3. ТУЗ-ийн хурлыг БНСУ-д эсвэл Монгол улсад зохион байгуулах</b>					
1	Тээврийн зардал	7	2,600,000.0	1	18,200,000.0
2	Байрны хөлс (5 өдөр)	7	500,000.0	5	17,500,000.0
3	Визийн хураамж	7	50,000.0	1	350,000.0
4	Томилолт (5 өдөр)	7	125,000.0	5	4,375,000.0
	ТУЗ-ийн хурлыг БНСУ-д эсхүл Монгол Улсад зохион байгуулах зардлын нийт дүн				40,425,000.0
	<b>Нийт дүн</b>				<b>88,961,000.0</b>



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

№ 05

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны  
зардлын төсөв батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.6 дахь заалт, 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны зардлын төсвийг 1 дүгээр Хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, зардал хэтрүүлэхгүй, гишүүдийн цалин хөлсийг тэдний ажлын үр дүнг харгалзан олгож байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

**ХУРЛЫН ДАРГА**



**Ч.ПҮРЭВСҮРЭН**



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

№ 06

Улаанбаатар хот

**Үл хөдлөх хөрөнгийг данснаас хасах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дэх заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.6 дахь заалт, 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 10.9 сая төгрөгийн анхны өртөгтэй, 7.80 сая төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий 1 давхар, 35 м.кв талбайтай үл хөдлөх хөрөнгө, 5.5 сая төгрөгийн анхны өртөг бүхий 4 ширхэг барилгын суурийг тус тус үндсэн хөрөнгөөс хасахаар шийдвэрлэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 141 дүгээр хурлын № 2 тоот тогтоол, 2013 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн 116 дугаар хурлын № 7 тоот тогтоолыг тус тус баталсугай.
2. Үндсэн хөрөнгө данснаас хасах ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг гүйцэтгэх захирал (М.Алтан-Очир)-г, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд тус тус даалгасугай.

**ХУРЛЫН ДАРГА**



**Ч.ПҮРЭВСҮРЭН**